

Гарчиг

1. Танилцуулга
 - 1.1. Интернэт банк үйлчилгээ
 - 1.2. Интернэт банкны үйлчилгээний төрлүүд
 - 1.3. Интернэт банкны хэрэглэгч болох
2. Хэрэглэх заавар
 - 2.1. Үйлчилгээнд нэвтрэх
 - 2.2. Лавлагаа авах
 - 2.3. Гүйлгээ хийх
 - 2.3.1 Програм суулгах ба тохиргоо
 - 2.3.2 Гүйлгээ хийх алхамууд
3. Санамж, Зөвлөгөө

1. Танилцуулга

1.1 Интернэт банк үйлчилгээ

Та манай интернэт банкны үйлчилгээг ашиглан орон зай, цаг хугацаагаар хязгаарлагдахгүйгээр интернэтэд холбогдсон компьютерийн тусламжтай банкн санхүүгийн бүрэн үйлчилгээг авах боломжтой юм.

1.2 Интернэт банкны үйлчилгээний төрлүүд

Манай интернэт банкны үйлчилгээ нь танд **Лавлагаа авах** болон **Гүйлгээ хийх** гэсэн хоёр төрлийн үйлчилгээг санал болгож байна.

Интернэт банкны жилийн хураамж :

- Лавлагааны эрх - **Үнэгүй**
- Гүйлгээний эрх - 3,000 төгрөг

Лавлагаа авах үйлчилгээг хэрэглэн дансны жагсаалт харах, дансны хуулга харах, файлаар болон хэвлэж авах, валютын ханш лавлах боломжтой болох юм.

Гүйлгээ хийх үйлчилгээ нь лавлагаа авах үйлчилгээнээс гадна өөрийн данс хооронд шилжүүлэг, банк хоорондын шилжүүлэг болон захиалгат төлбөр хийх боломжтой юм.

Интернэт сүлжээгээр санхүүгийн гүйлгээ хийхэд нууцлал аюулгүй байдлыг хангахаар электрон гарын үсэг буюу нэмэлт нууц код хэрэглэдэг. Манай интернэт банкны үйлчилгээний нэг онцлог нь уг кодыг тусгай төхөөрөмж /Жишээ нь: ихэнх бусад банкын хэрэглэдэг Васко төхөөрөмж нь 35000-45000 төгрөгийн үнэтэй/ хэрэглэдэггүй бөгөөд уг төхөөрөмжийн оронд та дараахь шаардлагыг хангасан гар утсан дээрээ **НЭГ УДААГИЙН НУУЦ ҮГ ҮҮСГЭГЧ /GSMOTR/** програм суулгах шаардлагатай:

- Интернэт холбогддог байх. WAP буюу үүрэн телефоны оператороор дамжин интернэт ордог бол програм ажиллахгүй.
- JAVA технологи дэмждэг байх. Гар утсан дээр ямар нэгэн java програмтай эсэхийг шалгаж эсвэл java програм суулган ажиллуулснаар java дэмждэг эсэхийг мэдэж болно.

1.2 Интернэт банкны хэрэглэгч болох

Та манай интернэт банкны хэрэглэгч болохыг хүсвэл банкны аль нэг салбар тооцооны төв дээр дараахь материалуудыг бүрдүүлэн ирж интернэт банкны үйлчилгээний хүсэлтийг бөглөх хэрэгтэй.

- Хувь хүн / иргэний үнэмлэх /
- Байгууллага / баталгаат гарын үсэг, тамга тэмдэг бүхий албан хүсэлт/

Хүсэлт бөглөхөд анхаарах зүйлс:

- Харилцагчийн нэр буюу таны үйлчилгээнд нэвтрэх нэр нь латин үсэг, тоо болон “_” (доогуур зураас)-наас бүтсэн байхыг анхаарна уу.
- Нэвтрэх нууц үг болон интернэт банкны бусад мэдээллүүдийг таны e-mail хаяг руу илгээх тул e-mail хаягаа зөв оруулсан эсэхээ шалгаарай.
- **Гүйлгээ хийх** үйлчилгээнд бүртгүүлэх харилцагчид “2.2 ИНТЕРНЭТ БАНКААР ГҮЙЛГЭЭ ХИЙХ ЗААВАР”-ийг харна уу.

2. Хэрэглэх заавар

2.1 Үйлчилгээнд нэвтрэх

Та www.ubcbank.mn хаягаар Улаанбаатар Хотын Банкны үндсэн сайтад холбогдож “Цахим банкинд нэвтрэх” хэсгийн “Интернэт банк” линкээр дамжин орно уу. Нэвтрэх хуудасны ЗЭРЭГЛЭЛ 2 гэснээс “үйлчилгээнд нэвтрэхийн тулд **ЭНД** дарна уу” гэсэн дээр дарж орох эсвэл шууд <http://www.ubcbank.mn/ebank> линкээр орж болно.

1. Нэвтрэх хэсэг



УЛААНБААТАР ХОТЫН БАНК

ТАНИЛЦУУЛГА | НЭВТРЭХ | АШИГЛАХ ЗААВАР | ENGLISH

Улаанбаатар хотын банкны Интернэт Банкны Үйлчилгээнд Тавтай Морилно уу!

Та өөрийнхөө хувийн болон байгууллагынхаа дансанд холбогдохын тулд харилцагчийн нэр, нэвтрэх нууц үг, Нэг удаагийн нууц дугаараа оруулаад НЭВТРЭХ товчийг дарна уу.

Харилцагчийн нэр

Нэвтрэх нууц үг

Нууц үг мартсан

Та нэвтрэхийн тулд e-mail-ээр хүлээн авсан нэр болон нэвтрэх нууц үгээ дээр зурагнаас харагдаж байгаа “Харилцагчийн нэр”, “Нэвтрэх нууц үг” талбарт оруулах хэрэгтэй. Нууц үгийг 3 удаа буруу хийвэл таны үйлчилгээний эрх блоклогдохыг анхаарна уу.

2. Нууц үг солих

Анх удаа холбогдоход НУУЦ ҮГ СОЛИХ хэсэг гарч ирэх ба та нэвтрэх нууц үгээ солих хэрэгтэй.

Нууц үг

Хуучин нууц үг

Шинэ нууц үг

Шинэ нууц үг давтах

2.2 Лавлагаа авах

Интернэт банкны үндсэн цэс нь дараах байдалтай дэлгэцний зүүн хэсэгт харагдах ба ардаа хар сумтай цэснүүд нь дэд цэсүүдэд задрана.

Лавлагаа цэс нь дараахь гурван дэд цэсэд задрана.

Харилцагчийн мэдээлэл цэснээс банкинд бүртгэгдсэн өөрийн мэдээллийг харах боломжтой.

Дансны жагсаалт цэснээс та интернэт банк үйлчилгээнд бүртгүүлсэн өөрийн дансуудын жагсаалт болон одоогийн үлдэгдлийг харна.

3. Үндсэн цэс

:: Эхлэл хуудас	
:: Лавлагаа	: Харилцагчийн мэдээлэл
:: Гүйлгээ хийх	: Дансны жагсаалт
:: Гүйлгээний лавлагаа	: Дансны хуулга
:: Нэхэмжлэх	
:: Захиалгат төлбөр	
:: Гүйлгээний загвар	
:: Валютын ханш	
:: Нууц үг солих	
:: Ашиглах заавар	
:: Шуудангийн хайрцаг	
:: Гаргах	

Дансны хуулга цэснээс та өөрийн аль нэг дансныхаа хуулгыг дээд тал нь 3 сарын хугацаатайгаар харах боломжтой. Өөрөөр хэлбэл та сүүлийн бүтэн жилийн хуулгыг авахын тулд 4 удаа 3 сарын зөрүүтэй хугацаануудыг тохируулах хэрэгтэй юм. Мөн та дансны хуулга хэвлэж авахаас гадна **PDF, XLS** (эксэлийн файл) өргөтгөлтэй файлаар хадгалж болно.

2.3 Гүйлгээ хийх

Интернэт банкаар гүйлгээ хийхэд гүйлгээний нууцлал болон аюулгүй байдалд зориулж онлайн сүлжээний хэрэглэгчийг таних дахин давтагдашгүй электрон гарын үсэг буюу харилцагчийн гүйлгээний код /цаашид нэг удаагийн нууц үг гэх болно/ шаардлагатай байдаг.

Манай банкны интернэтээр гүйлгээ хийх үйлчилгээний онцлог нь танд гүйлгээний нууцлалын баталгаа болох нэг удаагийн нууц үг үүсгэх “Васко” электрон төхөөржний оронд өөрийн гар утсыг хэрэглэх санал болгож байгаа юм. Ингэхийн тулд таны гар утас дараахь шаардлагыг хангасан байх хэрэгтэй:

Интернэт банкаар гүйлгээ хийхийн тулд та гар утсан дээрээ **НЭГ УДААГИЙН НУУЦ ҮГ ҮҮСГЭГЧ /GCMOTP/** програм суулгаж гүйлгээ хийхийн өмнө “Гүйлгээний нууц үг” талбарт оруулах нууц үгийг үүсгэж авах юм.

2.3.1 Програм суулгах ба тохиргоо

Алхам 1 – Хайлт

а. Android системтэй утас

Хэрэв таны гар утас Android үйлдлийн системтэй бол утасныхаа Android market (зарим утсан дээр Market, Playstore гэж байдаг) буюу өөрийн утсанд зориулсан програм татдаг цэс рүү орж “**gcm otp generator**” гэж бичиж хайхад “GCM OTP Generator” /Grapecity Mongolia LLC/ гэсэн илэрц гарсныг татаж суулгана.

б. iPhone утас

Хэрэв таны гар утас iPhone болн “appstore” гэсэн цэс рүү орж “**gcm otp generator**” гэж бичиж хайгаад “GCM OTP Generator” /Grapecity Mongolia LLC/ гэсэн илэрц гарсныг татаж суулгана.

в. Бусад утас

Та гар утасныхаа интернэт хөтөч /internet browser/ -ийн хаягийн хэсэгт дараахь зурагт үзүүлсэн байдалтайгаар хаягийг бичиж програм татах хэсэгт холбогдоно. “Нэг удаагийн нууц үг үүсгэгч татах” гэсэн линкэн дээр дарж програмыг татан суулгана.

Алхам 2 – Тохиргоо

Нэг удаагийн нууц үг үүсгэгч програмыг татаж суулгаад ажиллуулахын өмнө та дараахь тохиргоог хийсэн байх шаардлагатай.



Програмын тохиргоо цэс рүү орж “Серверийн хаяг” болон “Сериал дугаар”-ийг тохируулна.


Серверийн хаяг - <http://202.131.228.170:9083>

Сериал дугаар нь 10 оронтой тоон код байх ба таныг үйлчилгээнд бүртгэсэн теллер системээс лавлаж өгнө.

- Таны гар утас интернэтэд холбогддог байх.
- Гүйлгээний нууц үг үүсгэх “Нэг удаагийн нууц үүсгэгч” /One Time Password Generator/ програм таны утсанд суусан байх.
- Таны гар утас Java технологийг дэмждэг байх. Хэрэв таны гар утас java технологийг дэмждэггүй бол үйлдэл хийхэд “*Server not found! java.io.IOException:Error in HTTP operation.*” гэсэн алдаа гарна.

2.3.2 Гүйлгээ хийх алхамууд

Интернэт банкны гүйлгээ хийх цэс нь дараахь байдалтай харагдана. Та өөрийн хийх гэж буй гүйлгээндээ тохируулан сонголтоо хийх хэрэгтэй. Жишээлбэл: Та “Өөрийн данс хооронд” гэсэн сонголтыг хийвэл манай интернэт банк үйлчилгээнд бүртгүүлсэн дансуудын хооронд гүйлгээ хийх боломжтой.



Алхам 1 – Гүйлгээний мэдээлэл оруулах

Гүйлгээ хийх - УБХ банк доторх гүйлгээ - Өөрийн данс хооронд
 Төв, салбар, тооцооны төв хооронд
 Бусад банк руу - Дотоодын банк руу
 Гадаадын банк руу
 Багц гүйлгээ

Гүйлгээ хийх цэс нь дээрх байдлаар задрах ба өөрийн хийх гэж буй гүйлгээнд тохируулж сонгоно.

Гүйлгээний төрлөө сонгоод дараахь талбаруудыг бөглөх хэрэгтэй:

УЛААНБААТАР
ХОТЫН БАНК

English

ЧУЛУУНБААТАР ЗОЛБОО Интернет банкинд холбогдсон огноо: 2012.05.16

- ≡ Эхлэл хүүдас
- ≡ Лавлагаа
- ≡ Гүйлгээ хийх
- ≡ Гүйлгээний лавлагаа
- ≡ Нэхэмжлэх
- ≡ Захиалгат төлбөр
- ≡ Гүйлгээний загвар
- ≡ Валютын ханш
- ≡ Нүүц үг солих
- ≡ Ашиглах заавар
- ≡ Шуудангийн хайрцаг
- ≡ Гаргах

Дотоодын банк хоорондын шилжүүлэг

Шилжүүлэгчийн данс	MNT - 2600072228
Хүлээн авагчийн данс	501515854796
Хүлээн авагчийн дансны валют	MNT
<input checked="" type="radio"/> Шилжүүлэгчийн дансны валютаар <input type="radio"/> Хүлээн авагчийн дансны валютаар	
Шилжүүлэх дүн	100,000.00
Дүн хөрвүүлэх Шилжүүлэг хийх дансны валютууд ялгаатай тохиолдолд дүнг хөрвүүлэх шаардлагатай	
Очих банк	01 МОНГОЛ БАНК
Очих салбар	0000 ТӨВ МОНГОЛ БАНК
Хүлээн авагчийн нэр, хаяг	Овог Нэр, Хаяг
Төлбөрийн зориулалт	Авто машины татвар

Гүйлгээг загвар болгон хадгалах

Загварын нэр

Харилцагчийн бөглөсөн мэдээлэл буруу буюу дутуугаас үүдэн гарах аливаа хариуцлага, зардлыг харилцагч өөрөө хариуцна.

Үргэлжлүүлэх >>

Валют	Авах	Зарах
CNY	207.74	0.00
EUR	1,648.87	0.00
USD	1,305.00	1,324.00

Танд интернет банкны үйлчилгээтэй холбоотой санал, хүсэлт, лавлах зүйлс байвал доорх хаягаар бидэнд хандана уу.
 Утас: (976-11) 331133
 Факс: (976-11) 311027
 И-мэйл: ebank@ubcb.mn

Та манай банкны бусад бүтээгдэхүүн, үйлчилгээнүүдийн талаар сонирхож

- Шилжүүлэгчийн данс - Аль данснаас гүйлгээ хийхээ сонгоно.
- Хүлээн авагчийн данс - Хүлээн авагчийн дансны дугаар оруулна. Банк хоорондын гүйлгээ хийх гэж байгаа бол хүлээн авах банк болон салбараа сонгоно. Хүлээн авах дансны салбарыг мэдэхгүй тохиолдолд төв салбарыг сонгох хэрэгтэй.
- Хүлээн авагчийн нэр, хаяг – Хүлээн авах хүний нэр, хаягийг оруулна.
- Төлбөрийн зориулалт - Гүйлгээний утгаа бичнэ.
- Загварын нэр - Нэг ижил гүйлгээг олон дахин хийх бол тухайн гүйлгээг загвар болгон хадгалж болох ба дараа удаа Гүйлгээний загвар цэс рүү орж дуудахад дээрх талбарууд автоматаар бөглөгдсөнөөр гарч ирэх болно. Тухайн гүйлгээг нэг л удаа хийх бол хоосон орхиж болно.

Алхам 2 – Гүйлгээний мэдээллийг баталгаажуулах

Гүйлгээ хийх талбаруудыг бөглөөд “үргэлжлүүлэх” дарахад таны бөглөсөн мэдээллүүд ангилагдан харагдах ба гүйлгээний нууц үг оруулах талбар гарч ирнэ.

- [=: Эхлэл хүүдас](#)
- [=: Лавлагаа](#)
- [=: Гүйлгээ хийх](#)
- [=: Гүйлгээний лавлагаа](#)
- [=: Нэхэмжлэх](#)
- [=: Захиалгат төлбөр](#)
- [=: Гүйлгээний загвар](#)
- [=: Валютын ханш](#)
- [=: Нууц үг солих](#)
- [=: Ашиглах заавар](#)
- [=: Шуудангийн хайрцаг](#)
- [=: Гаргах](#)

Валют	Авах	Зарах
CNY	207.74	0.00
EUR	1,648.87	0.00
USD	1,305.00	1,326.00

Танд интернет банкны үйлчилгээтэй холбоотой санал, хүсэлт, лавлах зүйлс байвал доорх хаягаар бидэнд хандана уу.
Утас: (976-11) 331133
Факс: (976-11) 311027
И-мэйл: ebank@ubcb.mn

Та манай банкны бусад бүтээгдэхүүн, үйлчилгээ нүүдийн талаар сонирхож байгаа бол доорх хаягуудаар хандана уу.
www.ubcbank.mn

ЧУЛУУНБААТАР ЗОЛБОО Интернэт банкинд холбогдсон огноо: 2012.05.16

Дотоодын банк хоорондын шилжүүлэг

Шилжүүлэгчийн мэдээлэл

Шилжүүлэгчийн данс

Шилжүүлэх дүн

Хүлээн авагчийн мэдээлэл

Хүлээн авагчийн данс

Хүлээн авагчийн дансны нэр

Хүлээн авах дүн

Хүлээн авагчийн банк

Хүлээн авагчийн салбар

Бусад мэдээлэл

Төлбөрийн зориулалт

Гүйлгээний нууц үг

Гүйлгээ хийхдээ Та дараах зүйлийг анхаарна уу !

- Ажлын өдөр 09:00 -15:30 цагийн хооронд хийгдэнэ.
- Ажлын өдөр 15:30 цагаас хойш хийгдэх гүйлгээ дараагийн ажлын өдөртөө багтан хүлээн авагчийн дансанд орно.
- Ажлын өдөр 09:30 -17:30 цагийн хооронд бүх төрлийн валютын арилжааны буюу хөрвүүлгийн гүйлгээ хийгдэх болохыг анхаарна уу !

Банкны ажлын өдөр өндөрлөсөн бол Таны хийх гүйлгээ дараагийн ажлын өдөр хийгдэх гүйлгээгээр тооцогдон орохыг анхаарна уу !

Та энэ гүйлгээг хийхдээ итгэлтэй байна уу?

Гүйлгээ хийх
< Буцах

- Гүйлгээний нууц үг гэдэгт та өөрийн гар утсанд суулгасан Нэг удаагийн нууц үг үүсгэгчийг хэрэглэн үүсгэсэн кодыг оруулж гүйлгээгээ хийнэ.

9

3 Санамж, Зөвлөгөө

- ✓ Таны хийсэн гүйлгээ амжилттай болсон, буцаагдсан, алдаатай болсон талаар банк таны бүртгүүлсэн и-мэйл хаягаар тань цаг тухайд нь мэдэгдэж байх тул ирсэн мэдээллийг шалгаж хянах, ирсэн мэдээлэлдээ анхааралтай хандаж байна уу!
- ✓ Тухайн өдрийн 17 цагаас хойш хийгдэж байгаа гадаад валютын гүйлгээ дараагийн ажлын өдрийн ханшаар тооцогдохыг анхаарна уу!
- ✓ Тухайн өдрийн 16 цагаас хойш хийгдэж байгаа банк хоорондын гүйлгээ дараагийн ажлын өдрөөр орох болохыг анхаарна уу!
- ✓ Хэрэв та нууц үгээ 3 удаа дараалан буруу оруулсан тохиолдолд хэрэглэгчийн эрх тань автоматаар хаагдах ба та бичиг баримтын хамт өөрийн биеэр банкин дээрээ ирнэ үү!
- ✓ Интернэт банкны үйлчилгээнд холбогдсон хэрэглэгчийн дэлгэцийн идэвхгүй хугацаа 10 минут байх бөгөөд энэ тохиолдолд “Гарах” төлөвт автоматаар шилжих ба та шаардлагатай бол дахин шинээр орох хэрэгтэй.
- ✓ Таны хувийн харилцагчийн мэдээлэлд өөрчлөлт гарсан даруйд **банкин дээрээ биеэр ирж мэдээллийн сандаа өөрчөлт оруулж байх хэрэгтэй.** Харилцагчийн өгсөн мэдээлэл буруу ташаа, өөрчлөлтийг цаг тухайд нь хийгээгүйтэ холбоотой гарах эрсдэлийг харилцагч өөрөө хариуцах тул та хянамгай байна уу!